

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 5 дугаар багт байгуулах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил:

А. Талбайн тохижилтын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Г. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "IY" 81-95-12-г мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.

Е. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн тохижилтын ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэнэ.

### 1. Талбайн газар шорооны ажил

Барилгын газар шороо, буурь, суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.

Талбай хийх газрыг нэлэнхүйд нь жигдлэн түрж тэгшлэх, сүл шороог индүүгээр нягтруулах шаардлагатай. Гадаргуун тэгшилгээ, нягтруулгыг бүрэн хийсний дараа дараагийн үе шатны ажлыг эхлүүлнэ.

### 2. Сагсны талбай

Тэгшилсэн гадаргууд хайргаар нягтруулалт хийж дэвсгэр үе хийнэ. Сагсны талбайг 10см-ийн зузаан БМ100 маркийн бетоноор цутгаж хийнэ. Цутгалт авахын өмнө болон дараа нь бетоны арчилгааг сайтар хийж пленк дэвсэх, хучих, хэв гажилтын заадал гаргах зэрэг ажлуудыг технологийн дагуу гүйцэтгэнэ. Талбайд буусан бороо цасны усыг зайлзуулахын тулд цутгалт хийхдээ бага зэргийн хэвгий гаргаж өгнө.

Бетоны гадаргууг жигд өнгөлж, хөрсжүүлэгч турхсэний дараа зориулалтын будгаар өнгө ялгаж 2 үе стандартын дагуу будна.

### 3. Сагсны талбайн төмөр торон хашааны ажил

Сагсан бөмбөгийн талбайн хашааны өндөр 3м-тэй байх ба хашааны шонг БМ100 маркийн бетоноор хамгийн багадаа 80 см-ийн гунд цутгаж суурилуулна. Бага насны хүүхдүүд хашаа руу амарч торыг гагнасаар нь салгах, салхины үйлчлэл ихтэй тул хашаа ханарч нурах асуудал их гардаг тул торыг их рамтай нь бэхэлж, полсвой төмрөөр бүслүүрдэн гагнах болон хашааны хөшүүн чанарыг сайтар хангах шаардлагатай.